



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 10 сарын 25 өдөр

Дугаар 462

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 168, 2022 оны 204 дүгээр тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор төрийн өмчит байгууллага, аж ахуйн нэгжээс татан төвлөрүүлсэн 12 нэрийн, нийт 1,009,388,954.29 (нэг тэрбум есөн сая гурван зуун наян найман мянга есөн зуун тавин дөрвөн төгрөг хорин есөн мөнгө) төгрөгийн балансын үнэ, 808,204,748.71 (найман зуун найман сая хоёр зуун дөрвөн мянга долоон зуун дөчин найман төгрөг далан нэгэн мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу Цагдаагийн ерөнхий газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Цагдаагийн ерөнхий газрын дарга, хошууч генерал Ж.Болд, “Засгийн газрын авто бааз” улсын төсөвт үйлдвэрийн газрын захирал Г.Чинзориг, хавсралтад заасан төрийн өмчит байгууллагын дарга, захирал нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Автомашины төлбөр, хураамжийг бүрэн барагдуулж, зөрчлийг арилган, улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлийг шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг 2022 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-г үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ
132003443



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2022 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн
267 дугаар тогтоолын хавсралт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор төрийн өмчийн байгууллага,
аж ахуйн нэгжээс татан төвлөрүүлсэн, Цагдаагийн ерөнхий газарт балансаас
балансад шилжүүлэх автомашины жагсаалт

№	Шилжүүлэн өгөх байгууллагын нэр	Хөрөнгийн нэр	Үйлдвэрлэсэн, ношсон он	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)
1	Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн судалгаа хөгжлийн төв	Ландкруйзер-100, 400ЗУБК,	2003/ 2003	70,731,900.00	70,731,900.00	0.00
2	"Дулааны цахилгаан станц-4" ТӨХК	Тоёота Ланд круйзер-200, 0036УБТ,	2010/ 2011	148,848,707.29	148,848,707.29	0.00
3	Боловсролын мэдээллийн технологийн төв	Тоёота Ланд круйзер, 3192УБЧ,	2011/ 2011	28,020,000.00	8,172,500.00	19,847,500.00
4	Замын-Үүд чөлөөт бүс	Тоёота Ланд круйзер-200, 0985УНУ,	2008/ 2010	12,000,000.00	1,333,333.32	10,666,666.68
5	Үндэсний аудитын газар	Автомашин-Nissan Patrol- У62, 0578УАК,	2019/ 2020	170,000,000.00	29,547,619.10	140,452,380.90
6	Төрийн банк	ТОЁОТА РАВ-4, 3865УНЕ,	2008/ 2011	34,389,000.00	34,389,000.00	0.00
7	"МИАТ" ТӨХК	ХЮНДАЙ Соната-7, 0717УНЗ,	2010/ 2011	32,846,067.00	32,846,067.00	0.00
8	"Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ	Мерседес Бенз, 1535УНУ,	2011/ 2018	30,000,000.00	7,500,000.00	22,500,000.00

9	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ	Тоёота Ланд крузер-200, 1279УБР,	2007/ 2014	196,467,000.00	190,036,360.00	6,430,640.00
10	Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ	Ниссан Патрол Y61, 7574ОРХ,	2007/ 2014	120,534,000.00	119,246,982.00	1,287,018.00
11	"Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК	Тоёота Ланд крузер-200, 0038ОРА,	2012/ 2012	129,090,910.00	129,090,910.00	0.00
12	Иргэний нисэхийн ерөнхий газар	Киа Опирус, 0160УБИ	2010/ 2010	36,461,370.00	36,461,370.00	0.00
	Нийт дүн			1,009,388,954.29 (нэг тэрбум есөн сая гурван зуун наян найман мянга есөн зуун тавин дөрвөн төгрөг хорин есөн мөнгө)	808,204,748.71 (найман зуун найман сая хоёр зуун дөрвөн мянга долоон зуун дөчин найман төгрөг далан нэгэн мөнгө)	201,184,205.58 (хоёр зуун нэг сая нэг зуун наян дөрвөн мянга хоёр зуун таван төгрөг тавин найман мөнгө)